



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 0183

Хэрлэн сум

Нүүрс худалдан авахад зориулж  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын №02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн суманд байрлах "Бэрх-Уул" ХК-ийн Чандганы уурхайн нүүрсний чанар муу байгаатай холбогдуулан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн халаалтын хэвийн үйл ажиллагаа алдагдаж хөлдөлт үүсэх эрсдэл өндөр байгаа тул "Багануур" ХК-аас 400 тн нүүрс татан авахад шаардагдах 20,900,000 (хорин сая есөн зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ